

Зургийг ажиглаарай. “Гэгээн хүслэн” гэсэн утга санааг зураач ямар өнгөөр илэрхийлсэн байна вэ?



Д.Булгантуяа “Гэгээн хүслэн” 2017 он

ГЭГЭЭН ХҮСЛЭН


Дүрслэх урлаг, хөгжим аль аль нь хүний сэтгэл, амьдралыг , бодол хүслийг өөрийн гэсэн аргаар илэрхийлдэг. Гагцхүү үзэгч сонсогчид түүнийг өөрийнхөөрөө тайлна.

Зураач Д.Булгантуяа

“Хүслэн” хэмээх сэдвээр 20 орчим цуврал зураг бүтээжээ.Тэдгээрээс “Гэгээн хүслэн” бүтээлийнхээ тухай:
Тодорхойгүй бодит бус дүрслэл, зураас, дүрс, хөдөлгөөн, дагнасан, дарагдсан, нэвчиж харагдах өнгө, эрс тэс ялгарамж.

Энэ бүхэн хүний төгсгөл үгүй мөнхийн хүслийг илтгэнэ. Хүн өөрийнхөө хүслийг олж мэдэх, харах, ухаарах боломж ХЭМЭЭЖЭЭ.

Хөгжмөө анхааралтай сонсоорой. “Гэгээн хүслэн” гэсэн утга санааг хөгжмийн зохиолч аялгууны ямар шинж төрхөөр илэрхийлсэн байна вэ?



Д.Булгантуяа “Гэгээн хүслэн” 2017 он



Түүний цуврал зургаас төрсөн мэдрэмжээ илэрхийлж хөгжмийн зохиолч С.Соронзонболд “Төгөлдөр хуурын цуврал аязууд” бичсэн байна .

Тэрээр: Зураачийн бүтээлийг хараад хөгжмийн зохиолчийн сэтгэлд ямар нэгэн төсөөлөл хэм хэмнэл, хөг эгшиг, ая аялгуу буух нь гарцаагүй.

Тэрхэн агшинд төрсөн аялгууг эгшиг тэмдэглэгээнд оруулсан.


Тодорхой дүрслэлгүй зураас ямар нэгэн сэжүүр хайлгүй амьдралын олон өнгө будгийг барьж төгөлдөр хуурын эгшгээр гаргахыг хичээсэн” гэжээ.

Сонсох үйл, ноотонд хийсэн ажиглалтанд тулгуурлан доорх үгийн сүлжээг бөглөөрэй.

Босоогоор:

1. Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсэн байна вэ?
4. Зохиолд ямар хэмжээтэй ноот хамгийн өргөн хэрэглэгдэж байна вэ?
5. Сэдэв аялгууны хамгийн оргил нь ямар эгшиг байна вэ?
7. Нооты ард тавигдсан цэг ямар үүрэгтэй вэ?
9. Зохиолын хурдыг тодорхойлсон Allegro хэмээх үг ямар утгатай вэ?

Хөндлөнгөөр:

2. Энэ ямар хэмжээтэй нооты зогсоц вэ? 
3. Тэмдэглэгээний утга юу вэ? *f*
6. Сэдэв аялгуунд хамгийн холын үсрэлт хэдэн өргий зайтай байна вэ?
8. Энэхүү аязыг хөгжмийн зохиолч зургийн утга санаа, өнгө будагтай зохицуулж ямар цомнол, дэвсгэр хөгд бичигдсэн бай вэ?
10. Зохиолын дунд хэсэгт хөгжмийн зохиолч Rit. Буюу Ритенуто гэсэн тэмдэглэгээ таьсан байдаг . Энэ юу гэсэн утгыг илтгэх вэ?

